

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсрол, Шинжлэх ухааны газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/120/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 115
танай _____ ны № _____ т

БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Ж.ГАНБОЛД
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол соёл урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020253

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>52374242.00</u>	<u>70659074.25</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	52374242.00	70659074.25
351	Түүхий эд материал	26730850.00	26730850.00
35110	Тусгай зориулалттай материал	26730850.00	26730850.00
354	Хангамжийн материал	25643392.00	43928224.25
35410	Бичиг хэргийн материал	384000.00	384000.00
35420	Аж ахуйн материал	23998192.00	42283024.25
35430	Сэлбэг хэрэгсэл	75000.00	75000.00
35450	Барилгын засварын материал	1186200.00	1186200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>512065005.61</u>	<u>504795573.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	512065005.61	504795573.02
392	Биет хөрөнгө	435109005.61	427839573.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	389876569.00	389876569.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-64574314.76	-76746622.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74155269.00	74155269.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23460000.00	-33171756.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183126534.40	215848210.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		134379605.45	152636266.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34380604.00	36855404.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27068510.94	-29393694.38
39209	Зам, гүүрийн байгууламж	621900.00	621900.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-422400.00	-422400.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	2852960.36	2852960.36
393	Биет бус хөрөнгө	76956000.00	76956000.00
39301	Програм хангамж	750000.00	750000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-750000.00	-750000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	76956000.00	76956000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>564439247.61</u>	<u>575454647.27</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	<u>578470.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	578470.00
413	Өглөг	0.00	578470.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	578470.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>564439247.61</u>	<u>574876177.27</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	564439247.61	574876177.27
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	553048860.02	553048860.02
51101	Өмч: - төрийн	553048860.02	553048860.02
512	Хуримтлагдсан үр дүн	-	-
		127556067.57	117119137.91
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-
		190440154.98	127556067.57

51220	Тайлант үеийн үр дүн	62884087.41	10436929.66
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	138946455.16	138946455.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	564439247.61	575454647.27

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1521586888.47	1717488062.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	125214344.47	72213885.21
120	Нийтлэг татварын бус орлого	125214344.47	72213885.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125214344.47	72213885.21
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	125214344.47	72213885.21
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1396372544.00	1645274177.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1337094500.00	1497840300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1337094500.00	1497840300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59278044.00	147433877.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	7680000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	73092700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21450000.00	17490000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30493544.00	49171177.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1458702801.06	1707051132.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1458702801.06	1707051132.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	462441495.20	552171357.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229115089.14	233574027.15
210101	Үндсэн цалин	165452228.77	174825898.17
210102	Нэмэгдэл	45001564.66	41792679.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9993500.00	10137363.68
210104	Урамшуулал	8667795.71	6818085.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30158400.00	31673300.00
210201	Тэтгэврийн даатгал	21593600.00	23108700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2141200.00	2141200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1713000.00	1712900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428200.00	428200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4282400.00	4282300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40837595.00	39428441.00
210301	Гэрэл, цахилгаан	3174430.00	2180471.00
210302	Түлш, халаалт	33476955.00	31655970.00
210303	Цэвэр, бохир ус	4186210.00	5592000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	60697569.47	73969743.96

210401	Бичиг хэрэг	705750.00	7609247.00
210402	Тээвэр, шатахуун	5252920.00	3836000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622600.00	366280.00
210404	Ном, хэвлэл	152900.00	27750.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	834060.00	12508000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	505000.00	567000.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	52624339.47	49055466.96
2107	Томилолт, зочны зардал	320800.00	272700.00
210702	Дотоод албан томилолт	320800.00	272700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51786124.00	100904047.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51786124.00	100904047.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49132417.59	72349098.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	383580.00	487050.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23549090.00	29396140.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25199747.59	42465908.59
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	996261305.86	1154879774.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	976517200.00	1146491900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	614453000.00	549213400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	361654200.00	596950500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410000.00	328000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19744105.86	8387874.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19744105.86	8387874.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	62884087.41	10436929.66
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	62884087.41	10436929.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1396372544.00	1645274177.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1396372544.00	1645274177.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1337094500.00	1497840300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1337094500.00	1497840300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	59278044.00	147433877.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	7680000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	0.00	73092700.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21450000.00	17490000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30493544.00	49171177.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1383966544.00	1616748277.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1383966544.00	1616748277.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	387705238.14	461868502.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229115089.14	233574027.15
210101	Үндсэн цалин	165452228.77	174825898.17
210102	Нэмэгдэл	45001564.66	41792679.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9993500.00	10137363.68
210104	Урамшуулал	8667795.71	6818085.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30158400.00	31673300.00
210201	Тэтгэврийн даатгал	21593600.00	23287100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2141200.00	1962800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1713000.00	1712900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428200.00	428200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4282400.00	4282300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40837595.00	38849971.00
210301	Гэрэл, цахилгаан	3174430.00	2180471.00
210302	Түлш, халаалт	33476955.00	31077500.00
210303	Цэвэр, бохир ус	4186210.00	5592000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7196410.00	23804007.00
210401	Бичиг хэрэг	382500.00	6334627.00
210402	Тээвэр, шатахуун	4742500.00	3834800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	622600.00	366280.00
210404	Ном, хэвлэл	152900.00	189000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	869610.00	12763200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	426300.00	316100.00
2107	Томилолт, зочны зардал	320800.00	272700.00
210702	Дотоод албан томилолт	320800.00	272700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54468156.00	101139357.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54468156.00	101139357.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25215288.00	32555140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	278800.00	237000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24936488.00	32318140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	996261305.86	1154879774.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	976517200.00	1146491900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	614453000.00	549213400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх	361654200.00	596950500.00

	дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410000.00	328000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19744105.86	8387874.85
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19744105.86	8387874.85
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12406000.00	28525900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12406000.00	28525900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12406000.00	28525900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12406000.00	28525900.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	26057100.00
223001	Бусад хөрөнгө	0.00	2468800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12406000.00	-28525900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	190,440,154.98	501,555,160.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	190,440,154.98	501,555,160.20
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	190,440,154.98	501,555,160.20
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	553,048,860.02	138,946,455.16	190,440,154.98	501,555,160.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	553,048,860.02	138,946,455.16	127,556,067.57	564,439,247.61
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,106,097,720.04	277,892,910.32	317,996,222.55	1,065,994,407.81
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	553,048,860.02	138,946,455.16	127,556,067.57	564,439,247.61
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз,	0.00	0.00	0.00	0.00

	гарз				
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,659,146,580.06	416,839,365.48	445,552,290.12	1,630,433,655.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1767512000.00	1491018077.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1767512000.00	1484633177.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	346217300.00	338141277.15
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	234616800.00	233574027.15
210101	Үндсэн цалин	176305500.00	174825898.17
210102	Нэмэгдэл	44188900.00	41792679.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10032000.00	10137363.68
210104	Урамшуулал	4090400.00	6818085.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31676000.00	31673300.00
210201	Тэтгэврийн даатгал	23108700.00	23287100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2141200.00	1962800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1712900.00	1712900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	428200.00	428200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4285000.00	4282300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39239000.00	38849971.00
210301	Гэрэл, цахилгаан	2569500.00	2180471.00
210302	Түлш, халаалт	31077500.00	31077500.00
210303	Цэвэр, бохир ус	5592000.00	5592000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5611600.00	5380680.00
210401	Бичиг хэрэг	359300.00	359300.00
210402	Тээвэр, шатахуун	3834800.00	3834800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	529200.00	366280.00
210404	Ном, хэвлэл	189000.00	189000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315200.00	315200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	384100.00	316100.00
2107	Томилолт, зочны зардал	272700.00	272700.00
210702	Дотоод албан томилолт	272700.00	272700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23934600.00	20999459.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23934600.00	20999459.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10866600.00	7391140.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	237000.00	237000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10629600.00	7154140.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1421294700.00	1146491900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1421294700.00	1146491900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	667227900.00	549213400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	753738800.00	596950500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328000.00	328000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	6384900.0
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	6384900.0
222001	Тоног төхөөрөмж	0.00	4884900.00
223001	Бусад хөрөнгө	0.00	1500000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1776480300.00	824748900.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1776480300.00	824748900.00
122005	Орон нутгийн төсвөөс	1776480300.00	824748900.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0.00	20.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	0.00	1.00
610001	Төсвийн байгууллага	0.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	19.00
620001	Удирдах ажилтан	0.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	0.00	6.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	145868225.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	123727225.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123727225.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18423327.00
210401	Бичиг хэрэг	5,975,327.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,448,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80139898.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,139,898.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25164000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,164,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1565652.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,565,652.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22141000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22141000.00
222001	Тоног төхөөрөмж	21,172,200.00
223001	Бусад хөрөнгө	968,800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	147433877.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	147433877.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,680,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	73,092,700.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,490,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	49,171,177.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсрол, Шинжлэх ухааны газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Булган аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол, Шинжлэх ухааны газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсрол, Шинжлэх ухааны газар нь тухайн нутаг дэвсгэрийнхээ боловсролын байгууллага, иргэдийг төрийн захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тэдний үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх болон Боловсролын багц хууль, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, бусад хууль тогтоомжийг өөрийн үйл ажиллагаанд удирдлага болгох үүрэг бөгөөд Булган аймгийн хэмжээнд салбарын хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, тэдний мэргэжил боловсролыг сайжруулж мэргэшүүлэх, хамран сургалт түүний тойргийг тогтоон, салбарын статистик хэрэгжүүлэн тайлагнаж, үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн туслах чиг үүрэгтэй үйл ажиллагааг хэрэгжүүлдэг агентлаг.

2021 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийн хүрээнд “Шинэ багш”, “Шинэ ирээдүй” дэд хөтөлбөрүүд, мөн боловсролын салбарт хэрэгжиж буй “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II”, “Тогтвортой хөгжлийн

боловсрол”, “Чадварлаг багш” үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байгаа бөгөөд хэрэгжилтийн явц 2021 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь байна.

1. Булган аймагт Боловсролын салбарт шинэчлэл хийх ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээний ментор байгууллагатай хамтран ажиллаж байгаа ба БШУ-ны сайдын баг, "Good school", Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн лектор Чила, “Шинэ Монгол” сургуулийн дэргэдэх "ЕБС-ийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх" төсөл, "Сайн сургууль таны дэргэд" ТББ, ASK Ү цахим платформтой хамтран ажиллаж байна. Тус онд Боловсролын газраас 73 удаагийн цахим болон танхимын сургалтыг давхацсан тоогоор 5230 гаруй багш, удирдах ажилтанд зохион байгуулж, мэргэжил боловсролыг нь дэмжин ажиллаад байна.

2. Булган аймагт “Тогтвортой Хөгжлийн Боловсрол”-ыг түүчээлэх, улсын хэмжээний загвар сургууль болох зорилготойгоор ЭӨЦС, Хишиг-Өндөр, Хялганат, Могод сумдын сургуулиуд уг төслийн үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

5. Удирдах ажилтны манлайлал, ур чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг хангах хүрээнд “ЕБС, СӨБ-ийн байгууллагын багшийг сонгон шалгаруулах” журмыг үндэслэн “Батламж” шалгалтыг жилд 2 удаа зохион байгуулж хүний нөөцийг ханган ажиллаж байна. Монгол улсын Боловсролын Их сургууль, БСУГ-ын дарга нарын хамтын ажиллагаа, гэрээний дагуу МУБИС, Боловсролын удирдлагын ухааны тэнхим, СӨБС-тай хамтран Булган аймгийн СӨБ, ЕБС-ийн багш, удирдах ажилтан, мэргэжилтнүүд нийт 47 хүн магистрийн сургалтад сургаж, сургалтын менежер, Боловсролын газрын мэргэжилтнүүдийг туршлага судлах аяллыг “Булган Хангай Хөгжлийн төлөө сан”-тай хамтран зохион байгуулж Булган аймгийн Боловсролын салбарын тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх талаар сургалтуудыг зохион байгууллаа.

6. Орчин цагийн боловсрол үүсч хөгжсөний 100 жилийн ойд зориулан "Байгууллага, мэргэжлээр сурталчлан таниулах ажлын хүрээнд Хутаг-Өндөр сумын улсын тэргүүний “Гацуурхан” цэцэрлэг нь МҮОНТ-тэй хамтран Монгол улсын гавьяат багш, хөгжмийн зохиолч С.Батболдын “Шинэ жил” дууны клипны зураг авалт хийгдэж, “Би мэргэжилдээ хайртай” Булган аймгийн Дүрслэх урлаг, дизайн технологийн багш, суралцагчдын ололт амжилт, түүхэн баримтат кино контентийг 40, 60 минутаар бэлтгэн аймаг, улсын ТВ-ээр сурталчиллаа.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол, Шинжлэх ухааны газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,485,303.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,853,03 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,397.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Боловсрол, Шинжлэх ухааны газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,015.3 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0
Бараа материал	52,374.2	70,659.0	18,284.8
Үндсэн хөрөнгө	512,065.0	504,795.5	-7,269.5
Нийт хөрөнгө	564,439.2	575,454.5	11,015.3
Өр төлбөр	0.0	578.4	578.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	564,439.2	574,876.1	-10,436.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	564,439.2	575,454.6	9,858.5

Бараа материалын данс 70,659.0 мянган төгрөг болж 18,284.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй худалдан авсан хангамжийн материал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 797,916.3 мянган төгрөг болж 35,196.4 мянган төгрөгөөр өссөн нь 28,525.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон тавилга эд хогшил нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 574,876.1 мянган төгрөг болж 10,436.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Боловсрол, Шинжлэх ухааны газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 195,901.1 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар, нийт зардал өмнөх оноос 248,348.3 мянган төгрөгөөр буюу 14.5 хувиар тус тус өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Боловсрол, Шинжлэх ухааны газар нь 2021 оны төсвийн төсөлд тэтгэмжээс тусдаа зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 502,539,7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 499,239,7 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 155,997,1 мянган төгрөгөөр бууруулан 346,542.6 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 346,542.6 мянган төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Боловсрол, Шинжлэх ухааны газрын бодлого хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,645,274.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, урсгал үйл ажиллагаанд 1,497,840.3 мянган төгрөгийг зарцуулж, 8,387.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

БШУЯ-с Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 11,747.8 мянган төгрөг, 2020-2021 оны хичээлийн сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариутгалд зориулсан санхүүжилт 12,448.0 мянган төгрөг, Ээлжит хичээлийн цахим контентын сан байгуулах санхүүжилт 19,000.0 төгрөг, Суралцагчдын мэдлэг, чадварын ялгаатай байдлыг оношлох, үнэлгээний сэдэв даалгавар боловсруулахад шаардагдах санхүүжилт 5,975.3 мянган төгрөгийн санхүүжилт.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж зардалд Хүн төрөлхтөн сансарт анх ниссэний 60 жилийн ой, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн он хүрээнд 7,680.0 мянган төгрөг.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5-р шат 73,092.7 мянган төгрөг.

АЗДТГазраас аймгийн боловсрол хэрэгжүүлж байгаа 17,490.0 мянган төгрөг, санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй хэдий ч санхүүгийн тайланд Тайлангийн хугацааны эцэст 578.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Мөн Шатахууны гэрээний дагуу олгодог 142.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу үнэ төлбөргүй орлогод бүртгэх хуулийг зөрчсөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 149 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа хоцроосон 20 мэдээлэл хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээлэл 81 хувьтай хэрэгжсэн байна.

Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлангийн хугацааны эцэст 578.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу авлага өглөг үүсгэхгүй байх. Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 135.8 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших . Шатахууны гэрээний дагуу олгодог 142.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байгаан заалтуудыг тус тус зөрчсөн тул зөвлөмж өглөө.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит итгэл үзүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар мэдээлэл технологийн зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,856.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

4.2 Акт

Аудитын явцад акт байхгүй.

4.3 Албан шаардлага

Аудитын явцад албан шаардага байхгүй.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 135.8 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших заалтыг зөрчсөн байна.

2. ***Өгсөн зөвлөмж:*** Анхан шатны баримтыг хууль, дүрмийн дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших

2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тайлангийн хугацааны эцэст 578.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтын дагуу "төсвийг зохистой удирдаж өр авлага үүсгэхгүй байх" гэсэн заалтын дагуу авлага өглөг үүсгэхгүй байх заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Өглөг авлагагүй ажиллах

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Шатахууны гэрээний дагуу олгодог 142.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтыг зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй орлогод бүртгэх

4 Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

4.2 Илрүүлэлт: Шилэн дансанд 5, 8 сарын 21 мэдээлэл хугацаа хоцроож, 6 000.0 мянган төгрөгийн Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн гүйлгээг шивж оруулаагүй байна.

Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/


Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	БШУГазар	4	6,856.2							4	6,856.2
Дүн		4	6,856.2							4	6,856.2

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН


АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР

